


# Байранд орохдоо эхлээд үүнийг шалгаа рай!!

## 1 Галын хорны байрлалыг шалгах



## 2 Аваарын шат болон аваарын гарцыг шалгах



## 3 Хоргодох байр хүртэлх замыг шалгах



Дээр нь! үүнийг бэлдэж, шалгаад гамшиг тохиоход урьдаас бэлтгэлтэй байгаарай!!

- ✓ Гамшгийн үед зориулсан хүнс, усыг гэртээ бэлдсэн байх!
- ✓ Тавилгаа нурж унахгүй байхаар бэхлэх!
- ✓ Аюулгүй байдлаа бусдад мэдээлэх аргыг шалгах!
- ✓ Гамшгийн үед авч гарах цүнх бэлдэх!
- ✓ Гамшгийн үеийн мэдээлэл хүргэх апп-ыг ухаалаг утсандаа суулгах.

## Хэрэгтэй мэдээлэл

- Гамшгаас хамгаалах гарын авлага (Saitama Prefecture)

Япон хэл

[https://www.pref.saitama.lg.jp/documents/112385/bousai\\_manualbook.pdf](https://www.pref.saitama.lg.jp/documents/112385/bousai_manualbook.pdf)



4 хэл дээр орчуулагдсан

<https://www.pref.saitama.lg.jp/a0401/library-info/20190801itsumo.html>



- Гамшгийн үед хэрэг болох апп болон вэбсайт (Cabinet Office)

14 хэл дээр орчуулагдсан

<https://www.bousai.go.jp/kokusai/web/index.html>



- Японд зочилж буй гадаад хүмүүст зориулсан гамшгийн үед мэдээлэл хүргэх апп Safety tips (Japan Tourism Agency)

14 улсын 15 хэл дээр орчуулагдсан

Үнэгүй татах



For Android



For iPhone

# Гамшиг тохиосон үед хэрэг болох хөтөч

## Гамшигийн үеийн авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Байрандаа орохдоо шалгаж бөглөн, нүдэнд харагдах газар наах эсвэл чухал газраа хадгалаарай.

### Газар хөдлөл

Гэнэт хүчтэй чичиргээ мэдрэгдвэл **ширээн доор нуугдах** зэргээр аюулгүй байдлаа хангахад анхаараарай.  
**Хаалгаа нээгээд, орох гарах гарцыг шалгаарай.** Тавиур, түүний дээр тавиастан зүйлс болон телевиз унаж ирэх магадлалтай тул түүнээс хол байж, чичиргээ намжихыг хүлээгээрэй.  
Яаран байрнаасаа гүйж гарахгүй байхад анхаараарай.

[Ишлэл, эх сурвалж]

**Гамшгаас хамгаалах гарын авлага (Fire and Disaster Management Agency)**

[https://www.fdma.go.jp/relocation/bousai\\_manual/index.html](https://www.fdma.go.jp/relocation/bousai_manual/index.html)



### Цунами

Одоогийн амьдарч буй түрээсийн байр нь далайн ойролцоо нам дор газар байрладаг бол цунами болон цунамигийн сэрэмжлүүлэг, анхааруулах мэдээнд анхаарал хандуулж, хүчтэй чичиргээ, эсвэл удаан урт чичиргээ мэдрэгдвэл **өндөр газарт очиж, аюулгүй байдлаа хангаарай.**

**Цунамигаас өөрийгөө хамгаалахын тулд (Japan Meteorological Agency)**

<https://www.jma.go.jp/jma/kishou/books/tsunami201501/index.html>



**Гарын авлага "Газар хөдлөл, цунамигийн аюулгүйн заавар" (Japan Meteorological Agency)**

[https://www.jma.go.jp/jma/kishou/books/eqtsunami\\_guidance/index.html](https://www.jma.go.jp/jma/kishou/books/eqtsunami_guidance/index.html)



### Хар салхи, аадар бороо

Гамшигт урьдаар бэлдэхийн сацуу нүүлгэн **шилжүүлэх мэдээний дагуу аюулгүй газарт хоргодоорой.**

**Өөрөө хийх гамшигийн бэлтгэл (Japan Meteorological Agency)**

[https://www.jma.go.jp/jma/kishou/known/ame\\_chuui/ame\\_chuui\\_p10.html](https://www.jma.go.jp/jma/kishou/known/ame_chuui/ame_chuui_p10.html)



**Нүүлгэн шилжүүлэх мэдээтэй холбоотой удирдамж (Cabinet Office)**

[https://www.oukyu/hinanjouhou/r3\\_hinanjouhou\\_guideline/](https://www.oukyu/hinanjouhou/r3_hinanjouhou_guideline/)



### Гал түймэр

Гал түймэр гарсан тохиолдолд хөршүүддээ чангаар хашгирч мэдэгдэн, **119 рүү залгаарай.**

Гал гарж эхлэвэл аваарын гарцыг эхэлж шалгаад, галын хор зэргийг ашиглан унтраана.

Байдал аюултай болж ирвэл унтраах гэж хэт улайралгүй, аюулгүй байдлаа хангаарай.

(Ганцаараа байх тохиолдолд гал унтраах анхан шатны арга хэмжээ авсныхаа дараа 119 рүү мэдэгдэх.)

**Англи хэл дээр хувилбар! Гал түймэр унтраах сургуулилтад ашиглаж болох видео контент (Osaka Chuo Fire Station)**

[https://www.city.osaka.lg.jp/shobo\\_chuo/page/0000515068.html](https://www.city.osaka.lg.jp/shobo_chuo/page/0000515068.html)



**Орон сууцанд галаас сэргийлэх 10 санамж (Tokyo Fire Department)**

[https://www.tfd.metro.tokyo.lg.jp/lfe/topics/10\\_kokoroe/index.html](https://www.tfd.metro.tokyo.lg.jp/lfe/topics/10_kokoroe/index.html)



#### Тог залгах арга

Тог тасарсан тохиолдолд эргэж иртэл нэлээд хугацаа орох нь бий. Холбоо барих боломжтой байхаар **гар утас, ухаалаг утасны цэнэглэгч (повер банк)-ийг бэлдэж тавиарай.**

Цахилгааны компанийн нэр

Утасны дугаар

#### Газ залгах арга

Газар хөдлөл, гал түймэр зэргийн аюулыг мэдрэн газ тасрах нь бий. **Газ метр дээрх улаан гэрэл анивчиж байвал тогтсон горимын дагуу удирдсанаар газыг нээх боломжтой.**

Газны компанийн нэр

Утасны дугаар

#### Ус залгах арга

Ус тасарсан үед **эргэж иртэл нэлээд хугацаа орох** нь бий. **Цэвэр ус урьдчилан бэлдэж тавиарай.**

Усны компанийн нэр

Утасны дугаар

#### Тоног төхөөрөмж залгах арга

Гамшигийн үед байрны тоног төхөөрөмжийг буцааж залгах арга ((Нийтийн сан) Японы түрээсийн орон сууцны хяналтын нийгэмлэг) **[14 хэл дээр орчуулагдсан]**

<https://welcome.jpm.jp/>



#### Хоргодох газар

Гэртээ аюултай байдал мэдрэгдэх, нүүлгэн шилжүүлэх заавар гарсан зэрэг тохиолдолд **аюулгүй газар руу зугтаарай.**

Хоргодох газар

#### Дуудлагын төв болон хянагч компанийн холбоо барих хаяг

Урт хугацаагаар нутаг буцах тохиолдол болон одоогийн байртай холбоотой асуудалтай зүйл байвал **дуудлагын төв болон хянагч компани руу холбоо бариарай.**

Дуудлагын төв болон хянагч компанийн нэр

Утасны дугаар